



МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК



МӨНГӨӨ ХЭРХЭН УДИРДАХ ВЭ? ӨРХИЙН ТӨСӨВ, ХУРИМТЛАЛ БА ХАДГАЛАМЖ

Улаанбаатар хот

2022 он




1.1. Орлого, түүнийг бүрдүүлэх боломж нөөц

Мөнгө нь өөрийн үнэ цэнээр бусад барааны үнэ цэнийг илэрхийлэх боломжийг олгодог санхүүгийн онцгой хэрэгсэл юм.

Орлого нь биеийн болон оюуны хөдөлмөрийн үр дүнд бий болдог. Хувь хүн өөрт байгаа мөнгөө хадгалуулах эсвэл хөрөнгө оруулах шийдвэр гаргасны үр дүнд орлого олох боломж бүрддэг.

“ Мөнгөний мөн чанар нь эд зүйлс биш, нийгмийн харилцаа болдог оршдог ”



Зураг 1.1. Орлогын эх үүсвэр



Хувь хүн аливаа хэлбэрийн аж ахуй эрхэлж орлого олбол энэ нь бизнесийн орлого болно. Бизнес эрхлэхийн тулд үндсэн дөрвөн төрлийн нөөц ашиглах ба үүнд газар, капитал, хөдөлмөр, ур чадвар зэрэг орно.



Зураг 1.2. Бизнесийн орлого бий болгоход шаардагдах нөөц



Хүмүүсийн орлогын байдлаас хамаарч амьдралын түвшин өөр өөр байдаг. Зарим хүн хэд хэдэн эх үүсвэрээс орлого олж байхад зарим нь орлогын ганц эх үүсвэртэй бол огт орлогын эх үүсвэргүй нэгэн ч бий.

ОРЛОГО НЭМЭГДҮҮЛЭХ АРГА ЗАМ

1



Мэргэжил, мэдлэгээ дээшлүүлэх замаар ажил албан тушаалаа өөрчлөх

2



Давхар ажил хийх

3



Өрхийн гишүүдийн хэн нэгэн нь ашигтай бизнес эрхлэх

4



Илүүдэл эд зүйлийг худалдан борлуулах

5



Банк болон бусад байгууллага, иргэдээс зээл авч хөрөнгө оруулах






Зураг 1.3. Орлого нэмэгдүүлэх арга зам



1.2. Зардал, түүнийг хэмнэх арга

Мөнгийг үр дүнтэй зарцуулах нь орлого олохоос ч илүү чухал. Тиймээс хүсэл дагасан хэрэглээ нь мөнгө хүрэлцэхгүй байх шалтгаан тул хүсэлд бус хэрэгцээндээ төвлөрч хязгаарлагдмал мөнгөө оновчтой удирдаж сурах нь амьдралын нэгэн ухаан билээ.

Зардлын төлөвлөлтөө хийхэд дараах зөвлөмжид анхаарлаа хандуулна уу

-  Зарцуулалт хийх зүйлс нь хэрэгцээ юу, эсвэл хүсэл үү? гэдгийг ялгаж таних;
-  Өргөн хэрэглээний барааны үнийн өсөлтийг харгалзан, хэрэглээндээ хяналт тавих;
-  Бэлэн мөнгөөр худалдан авалт хийх үед мөнгөний хариултыг бага гэлтгүй авч байх;
-  Амьдралын энгийн зүйлсээс таашаал авах;
-  Эд зүйлсээ гамнаж тордох бас хэмнэх;

	Худалдан авах чадвартаа тохирсон хэрэглээг сонгох		Зарим үйлчилгээнээс татгалзаж өөрөө гүйцэтгэх
	Эрүүл мэнддээ анхаарч эм тарианд зардал гаргахгүй байх		Архи, тамхи хэрэглэдэг муу зуршлыг болих
	Баяр ёслолыг өндөр зардлаар тэмдэглэхээс татгалзах, гэр бүлтэйгээ жаргалтай байх		




Зураг 1.4. Хэрэглээг хэмнэх арга








Ихэнх улс оронд иргэдийнх нь орлогоо хуваарилдаг хамгийн энгийн бөгөөд өргөн ашиглагддаг арга бол 50/20/30 хувиар төсөвлөх дүрэм юм. Уг дүрмийг баримталснаар орлогынхоо түвшнээс давсан зардал гаргахгүйгээр төсвийн оновчтой хуваарилалтыг хийж хуримтлал үүсгэдэг.

ОРЛОГОД ЭЗЛЭХ ЗАРДЛЫН ЗОХИСТОЙ ХУВЬ




30% ХҮСЭЛ

-  Хобби
-  Өөрийн гадаад үзэмж
-  Кино, урлаг

50% ХЭРЭГЦЭЭ

-  Байрны төлбөр
-  Хоол, хүнс
-  Эрүүл мэнд
-  Даатгал
-  Зайлшгүй шаардлагатай өдөр тутмын хэрэглээ

20% ХАДГАЛАМЖ

-  Хуримтлал
-  Хөрөнгө оруулалт
-  Гэнэтийн зүйл



Зураг 1.5. Орлогод эзлэх зардлын зохистой хувь¹

Хүн хэрэглээгээ зөв зохистой, аль болох хүрээлэн буй байгаль орчиндоо хор хөнөөлгүй, нийгэм-эдийн засагтаа үр ашигтай байх хэмжээнд хангах нь XXI зууны дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлага болсон “Тогтвортой хөгжил”-ийн үзэл санаанд нийцэх юм. Ингэснээр тогтвортой амьдралын хэв маяг бий болно.

¹ Өрхийн орлого, зарлагын зохистой хэмжээний 50/20/30-ийн дүрэм: Энэхүү арга нь орлогоо анх удаа төсөвлөхөөр шийдэж буй хувь хүн болон гэр бүлд тохиромжтой бөгөөд цаашдаа илүү нарийвчлалтай, өөртөө тааруулан орлогоо хуваарилах эхлэл алхам юм.



МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК



ӨРХИЙН ТӨСӨВ





2.1. Өрхийн төсөв, түүний бүтэц


Өрхийн орлого, зардлыг тооцож, төсөвлөх нь өрхийн гишүүдийн санхүүгийн гэнэтийн асуудалд орох нөхцөлийг бүрдүүлэхгүй ба тэгш хүртээмжтэй хуваарилагдах, хуримтлалыг бий болгоход ихээхэн ач холбогдолтой юм. Иймд өрхийн төсвийг хэрэгцээндээ хуваарилах тооцоолол, төлөвлөгөө гэж ойлгоно.

Өрхийн төсвийн зорилго нь өрхийн гишүүдийн материаллаг болон оюун санааны хэрэгцээг өрхийн хязгаарлагдмал нөөцөөр бүрэн дүүрэн хангахад чиглэдэг. Иймээс өрхийн төсвийн гол үүрэг нь өрхийн орлогыг зөв, үр ашигтай хуваарилж, зарцуулахад оршдог.


ОРЛОГО

-  Ажлын хөлс
-  Бүтээгдэхүүн, үйлчилгээ борлуулалт


ХУРИМТЛАЛ

-  Ирээдүйн хэрэгцээнд зориулан хадгалж, хуримтлуулсан мөнгө

ЗАРЛАГА

-  Хэрэгцээт бараа үйлчилгээ худалдан авахад зарцуулах мөнгө


ӨР ТӨЛБӨР

-  Бусдад болон тогтмол үйлчилгээний хөлсөнд төлөх мөнгө



Зураг 2.1. Өрхийн төсвийн үндсэн ойлголтууд

Өрхийн орлогыг олон шинжээр ангилж болох бөгөөд жил бүр МУ-ын ҮСХ-ноос өрхийн сарын дундаж орлогын бүтцийг тодорхойлон гаргадаг.



2.2. Монгол Улсын нэг өрхийн сарын дундаж орлогын бүтэц (2020 он 1 улирал)¹

¹ Эх сурвалж: МУ-ын Үндэсний Статистикийн Хороо



Өрхийн аж ахуй эрхлэх

Төсөл бичих, бизнес эрхлэх



Төсөл, хөтөлбөрт хамрагдах

Өрхийн гишүүдийг мэргэжилтэй болгох, боловсролыг дээшлүүлэх



Ажил хөдөлмөр эрхлэх

Хуримтлалтай болох



Хөрөнгө оруулалт хийх

2.3. Өрхийн орлого нэмэгдүүлэх боломж

2.2. Өрхийн төсөв зохиох аргачлал

Санхүүгийн сахилга баттай өрх нь улирал, хагас болон бүтэн жилээр өрхийн төсвийн төлөвлөгөөгөө гарган мөрддөг. Үүний тулд орлого, зарлагаа урьдчилж тооцоолсон байна. Өрхийнхөө төсвийг тогтмол хөтлөх явцдаа тодорхой хугацаанд хянаж, шинжилгээ хийгээд өнгөрсөн хугацаанд ямар зүйлд мөнгө их зарцуулсан, юунаас хэмнэлт гаргаж чадсанаа дүгнэх хэрэгтэй. Ингэснээр өрхийн гишүүн бүр санхүүгийн зөв дадал хэвшилд төлөвших сайн талтай.



2.4. Өрхийн төсөв зохиох үе шат



ДУГУЙТ

Зардлын төрөл бүрээр дугуйт бэлтгэн өрхийн төсвийнхөө тооцоог хуваарилж, төлөвлөгөөтэй зарцуулах



Өрхийн орлогыг зарцуулахын өмнө бага ч болов мөнгийг хуримтлалдаа тогтмол хийсний дараа хэрэглээндээ хуваарилна.

КОМПЬЮТЕР СИСТЕМ ашиглах


Компьютер, гар утсандаа өрхийн орлого, зарлагыг бүртгэн, төсөвлөх



Компьютер, гар утас дээр ажиллах дуртай хүмүүст олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөрийн "Төсөвчин" хэмээх ашиглахад хялбар цахим хувилбарыг санал болгож байна.

ХҮСНЭГГИЙН АРГА

Хүснэгтийн аргачлал нь сонгодог аргачлал ашигласан цаасан дээр бүртгэх хувилбар юм.



Төсвөө ямар хугацаанд хөтлөхөө төлөвлөж, өөртөө зорилго тавиарай. Гурав буюу түүнээс дээш сарын дараа зарлага өндөртэй сар болон орлого, зарлага их хэлбэлздэг мөчлөгийг тодорхойлж чадна.

МАТРИЦ дээр төлөвлөх

Зардлыг ангилснаар өрхийн орлогыг үр ашигтай хуваарилах



Матрицын аргыг ашигласнаар мөнгөө шаардлагатай зүйлсээс эхлэн зөв зарцуулж эхэлдэг болох давуу талтай.

2.5. Өрхийн төсөв зохиох аргачлал

+	Орлого	1 сар	2 сар	3 сар	4 сар	5 сар	6 сар
	Орлого						
-	Тогтмол зарлага	1 сар	2 сар	3 сар	4 сар	5 сар	6 сар
=	Төсөв						
-	Тогтмол бус зарлага						
=	Гарт үлдэх мөнгө						

2.6. Орлого, зарлагын жишээ



“Өрхийн төсвийн дэвтэр”

товхимлыг ХБНГУ-ын Хадгаламжийн Банкны Олон Улсын хамтын ажиллагааны сангаас Монголбанктай хамтран хэрэгжүүлж буй төслийн хүрээнд Монголын банкны холбоо, Хадгаламжийн даатгалын корпорацийн дэмжлэгтэйгээр боловсруулав.



2.7. Өрхийн дэвтэр

² Энэхүү дэвтрийг үнэгүй тараагдахаар хэвлэсэн.



2.3. Өрхийн төсөв хөтлөлтийн давуу тал, ач холбогдол



ӨРХИЙН ТӨСӨВ ХӨТЛӨХИЙН ДАВУУ ТАЛ



Гэр бүлийн санхүүгийн төлөвлөлт нээлттэй болсноор итгэлцэл илүү бат бөх



Төлөвлөснөөр гэр бүлийн гишүүн бүрт шаардлагатай төсөв хуваарилагдах



Нийгэм эдийн засгийн эрсдэлийг даван туулах арга замаа хайхад тусална



Санхүүгийн зорилготой болж ажил, амьдралаа төлөвлөж сурахад хялбар болдог



ӨРХИЙН ТӨСӨВӨӨ ХӨТЛӨХГҮЙ БАЙХЫН СӨРӨГ ТАЛ



Гэр бүлийнхээ санхүүгийн онцлог чанарыг мэдэхгүй, хэт үрэлгэн зардал их гаргадаг



Гэнэтийн эрсдэл төлөвлөгөөгүй зардал гарах үед гэр бүлийн амьдрал хүндрэлд орно



Өдөр тутмын тооцоогүй амьдрал нь эдийн засгийн хувьд эмзэг байдалд хүргэх улмаар ядууралд оруулдаг тохиолдол нилээдгүй юм



Өрхийн төсөв хөтлөхгүй байх нь хадгалах, хуримтлуулах боломжийг олгодоггүй

2.8. Өрхийн төсөв хөтлөлтийн давуу тал



Баян болох нь их мөнгө их олсноор бус харин хэрхэн яаж зарцуулахаас хамаарна. Та өнөөдрийн хувьд хэр хөрөнгөтэй хүн бэ? Дараах загварын дагуу өөрт байгаа хөрөнгө болон өр төлбөрөө тодорхойлно уу.

ХӨРӨНГӨ (А)	ӨР ТӨЛБӨР (Б)
Бэлэн мөнгө	Хувь хүнд төлөх өр
Хадгаламж	Ус цахилгааны төлбөр
Автомашин	Өр төлбөрийн дүн
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	ЦЭВЭР ХӨРӨНГӨ (В)

Цэвэр хөрөнгийн хэмжээг олохдоо хөрөнгийн нийт дүнгээс өр төлбөрийн нийт дүнг хасна.

Өөрөөр хэлбэл $B = A - Б$ гэсэн томъёог ашиглана.

Та өрхийн төсвөө цахим байдлаар хөтлөх бол www.sankhuuginbolovsrol.mn хаягаар орж нэмэлт мэдээлэл авч ашиглах боломжтой. Мөн “Төсөвчин” аппликейшнийг үнэгүй IOS, Android утсандаа суулган ашиглаарай.




МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК



ХУРИМТЛАЛ БА ХАДГАЛАМЖ



ГАРЬДЫН ГЭР БҮЛ



Сэдвийг амьдралд ойртуулах, ойлгомжтой болгох үүднээс Монголын мянга, мянган өрхийг төлөөлсөн Гарьдын гэр бүлийн гишүүдийн хийсвэр дүрийг жишээнд ашиглан айл өрх бүрт тулгардаг санхүүгийн асуудлыг зөв шийдвэрлэхэд туслахыг зорилоо. Та бүхэнд Гарьдын өрхийн гишүүдийг товч танилцуулъя.

Өвөө **Самбуу**
80 настай



Эмээ **Должин**
73 настай



Аав **Гарьд**
45 настай
Төрийн албан хаагч



Ээж **Алимаа**
43 настай
Эрхэлсэн ажилгүй



Том хүү **Тэмүүлэн**
25 настай



Бэр **Солонго**
24 настай



Дунд хүү **Тэнгис**
17 настай



Ач хүү **Хасар**
3 настай



Отгон охин **Тамир**
6 настай






3.1. Хуримтлалын зорилго, хуримтлал үүсгэх арга


Яагаад бид хуримтлалтай болох шаардлагатай вэ?

Бидний амьдралд урт, богино хугацааны төлөвлөж болох, төлөвлөж болохгүй бэлэн мөнгөний хэрэгцээ шаардлага гардаг. Энэ үед нэг бол хуримтлалаараа эсвэл зээл авах, эд хөрөнгөө худалдах байдлаар зохицуулах шаардлагатай болдог.


Мэдээж хамгийн сонгодог арга нь мөнгөн хуримтлалаараа гэнэтийн мөнгөний хэрэгцээгээ хангах явдал юм. Өөрөөр хэлбэл, зээл авбал та зээлийн хүү төлөх хэрэгтэй болно. Эд хөрөнгө зарж борлуулан богино хугацаанд бэлэн мөнгөтэй болохын тулд магадгүй зах зээлийн үнээс хямдаар зарахаас аргагүйд хүрнэ. Иймээс гэнэтийн хэрэгцээ шаардлагад бэлэн байх, хэтийн хүсэл, зорилгодоо хүрэхэд хуримтлал чухал.



Зураг 3.1. Хадгаламжийн зориулалт



Жишээ: Тэмүүлэн, Солонго хоёр орчин үеийн зурагт авахыг сүүлийн хэдэн жил бодсон хэдий ч санхүүгийн боломж бүрдэхгүй байсаар өдийг хүрчээ. Тэд энэ асуудлыг хэрхэн шийдэхээ ярилцаж байна.




Ломбарднаас
зээлэх үү?

Банкнаас зээл
авах уу?

Найзаасаа
зээлэх үү?

Зээл авахаар зээлийн
хүүнд илүү зардал
гарах гээд байдаг.

Энэ удаа хоёулаа
зээл аваад зурагтаа
авчихъя. Харин
одооноос хуримтлал
хийж эхэлье.



Хуримтлал үүсгэхийн
тулд дараа жил хүртэл
хойшлуулах уу?

Уг нь энэ жилд зурагтаа
авчихвал, тийм ээ?

Зөв санаа. Хоёулаа
амралтаараа аялалд
явахаа эртнээс төлөвлөж
хуримтлал хийж болно
шүү дээ.





Хуримтлал хийж эхлэх нь заримдаа тийм ч амар зүйл биш байдаг. Гэхдээ энэхүү амаргүй байдлыг давах нь мөнгө хуримтлуулах зорилго, төлөвлөгөөгөө гаргахаас эхэлнэ. Хуримтлалыг нэг өдөрт биш, алхам алхмаар хийх боломжтой.



Зураг 3.2. Хуримтлал үүсгэх алхамууд

1. Орлого, зардлаа бүртгэх

Төсөв зохиох нь маш энгийн бөгөөд дараах зүйлсийг амьдралдаа хэвшүүлэх нь үр дүнтэй.

- Сарын тогтмол болон нэмэлт тогтмол бус орлогуудаа бүртгэх;
- Өдөр бүрийнхээ зарцуулалтыг гарын дор дэвтэр гаргах эсвэл гар утсан дээрээ бүртгэх;
- Орлого, зардлаа бүртгэн өрхийнхөө төсвийг гаргаарай.

Сарынхаа орлого, зардлыг ийнхүү тооцох нь:






- Хэрвээ таны орлого зардлаасаа их байгаа бол шууд хуримтлуулж эхлээрэй.
- Орлого тань зардлаасаа илүү гарахгүй бол зардлаа хэмнэх боломжийг хайгаарай. Мөн орлогоо нэмэгдүүлэх боломжийг эрэлхийлээрэй.

2. Хэмнэж болох зардлыг хасч орлого болон зардлын төлөвлөгөө гаргах

Сарын эцэст зардал тус бүрийг нягтлан үзээд үр ашиггүй, илүү зардлыг танаж, хэмнэх боломж байгаа эсэхийг тодорхойл. Гэхдээ тэмдэглэлт баяр, төрсөн өдөр гэх мэт тогтмол бус нэмэлт зардлуудыг тусгахаа мартуузай. Мөн тогтмол орлого болон тогтмол бус орлого орж ирэх хугацааг нягталж, орлого нэмэгдүүлэх бодит боломжоо үнэлээрэй.



УХААЛАГ ХЭМНЭЛТ гэж юу вэ?

-  Төлөвлөгөөний дагуу худалдан авалт хийж хэвших;
-  Рекламд найдаж худалдан авалт хийхгүй байх;
-  Гадуур хооллохоо багасгах, өөртөө тохирсон эрүүл хоол хийж авч явах, гэртээ хооллох;
-  Цахилгаан, ус гэх мэт хэрэглээний зардлыг хянах;
-  Унаа шатахууны зардлыг хэмнэх, тухайлбал, алхах, нийтийн тээврээр зорчих, дугуй унах гэх мэтээр эрүүл мэнддээ тустай байдлаар шийдэх.

3. Хуримтлуулж чадах хэмжээгээ тодорхойлох

Ийнхүү өрхийнхөө төсвийг шинэчлэн гаргаж хуримтлал хийх боломжит хэмжээгээ тодорхойлно. Санхүүгийн мэргэжилтнүүд цэвэр орлогынхоо 10-15 хувийг хуримтлуулахыг зөвлөдөг. Мэдээж хуримтлал танд дарамт болж болохгүй. Хэмнэлт тань ухаалаг байх хэрэгтэй. Төсөв гаргаж, дээрээс нь хэмнэлт хийж сурсан байхад та санаанд оромгүй их мөнгийг хуримтлуулсан байх болно.

4. Хуримтлал хийх зорилгоо ач холбогдлоор нь жагсаан бичих

Хүн бүрийн хувьд харилцан адилгүй хамгийн чухал зүйлтэй байх тул өөрийнхөө хувьд цаг хугацаа, хуримтлалын хэмжээнээсээ хамааруулан хуримтлалаа хийх нь чухал юм.

5. Урт, богино хугацааны хуримтлалын зорилгоос хамааруулан хуримтлалынхаа хэлбэрийг сонгох

Урт, богино хугацааны зорилготойгоо уялдуулан хуримтлал хийх нь илүү үр дүнтэй байдаг. Тухайлбал, зорилгуудыг дараах байдлаар урт, богино хугацааных гэж ангилж болох юм. Үүнд: Богино хугацааны зорилгыг санхүүжүүлэхэд зориулсан хуримтлал /1-3 жилийн хугацаа/

- Гэнэтийн хэрэгцээнд зориулан хуримтлуулах /ажил хийхгүй байхдаа 6 сараас 1 жил амьдрах зардлаа нөхөх хэмжээний хуримтлал/

- Амралт зугаалга, аялалд зориулан хуримтлуулах

- Сурч боловсроход зориулан хуримтлуулах

- Шинэ машин худалдан авахад зориулан хуримтлуулах гэх мэт.

Урт хугацааны зорилгоо санхүүжүүлэхэд зориулсан хуримтлал /3 болон түүнээс дээш жилийн хугацаа/

- Тэтгэвэрт гарахдаа зориулан хуримтлал хийх

- Хүүхдийнхээ их дээд сургуулийн боловсролд нь зориулан хуримтлал хийх

- Байрны урьдчилгаа төлбөр бүрдүүлэх болон байрны засвар өргөтгөлд зориулан хуримтлуулах гэх мэт.



Урт, богино хугацааны зорилгоосоо хамааруулан хуримтлалын бүтээгдэхүүний төрөл хэлбэрийг зөв сонгох нь илүү үр дүнтэй. Өөрөөр хэлбэл, урт хугацааны зорилгодоо хуримтлал хийж байгаа бол 1 жилээс дээш хугацаатай хадгаламжийг сонгох, богино хугацааны зорилгодоо хуримтлал хийх бол 1 жилээс богино хугацаатай хадгаламжийг сонгох нь төлөвлөсөн хадгаламжийн хүүний орлогыг эрсдэлгүйгээр (хадгаламжийнхаа хугацааг цуцлуулж бага хүүтэй хадгаламж авахгүй) авах боломжийг бүрдүүлдэг.

6. Хуримтлалаа эхлүүлж, хэрхэн өсч байгааг хянаж байх

Нэгэнт та хуримтлал хийхээр шийдсэн бол цалин, орлогоосоо шууд хадгаламжийн данс руугаа тодорхой өдрүүдэд тогтмол дүнгээр мөнгөө автоматаар шилжүүлбэл илүү үр дүнтэй.

Эцэст нь таны хуримтлал таны бодож төлөвлөсний дагуу өсөх болно. Хуримтлалтай болох дээрх үйл явцыг сар бүр хянаж, хуримтлал хийх төлөвлөгөөгөө хэрэгжүүлж чадвал хүссэн хэмжээний хуримтлалаа хийж санхүүгийн гэнэтийн эрсдэлээс өөрийгөө хамгаалж чадна.

3.2. Хадгаламжийн төрөл, түүний давуу ба сул тал

Банкинд хадгалуулах нь мөнгөө хадгалуулах эрсдэл багатай арга юм. Хадгаламж нь хугацаатай болон хугацаагүй гэсэн үндсэн төрөлтэй байдаг.



ХУГАЦААГҮЙ ХАДГАЛАМЖ

Та мөнгөө богино хугацаанд ашиглахаар төсөвлөсөн эсвэл гэнэтийн зардалд зарцуулахаар төлөвлөсөн бол хугацаагүй хадгаламжийг сонгох нь ашигтай.

Харилцах данс

Өдөр тутмын төлбөр тооцоо төлөхөд ашиглах хүүгүй эсвэл маш бага хүүтэй байдаг.



ХУГАЦААТАЙ ХАДГАЛАМЖ

Та тодорхой зорилготойгоор хуримтлуулах, мөнгөнийхөө хэрэгцээг хугацааны хувьд төлөвлөх боломжтой бол хугацаатай хадгаламжийг сонгох нь ашигтай.

Тодорхой хугацаатай хадгаламж

1, 3, 6, 12 сар болон түүнээс дээш хугацаатай хадгаламжийн бүтээгдэхүүн банкууд санал болгодог.

Зураг 3.3. Хадгаламжийн төрөл



Хугацаагүй хадгаламж


Харилцах данстай ижил боловч хүүний хувьд өндөр байдаг. Жишээлбэл банкууд жилийн 6% хүртэл хүү санал болгож байгаа гэж авч үзвэл хүүний төлбөрийг жил бүрийн сүүлийн өдөр дансанд шилжүүлнэ. Нэг сул тал нь банк хадгаламжийн хүүгээ бууруулахад таны хадгаламжийн хүү буурна. Харин давуу тал нь банкны хүү нэмэгдвэл таны хүү мөн нэмэгдэнэ.


Энэ нь хугацаагүй хадгаламжтай харьцуулахад өндөр хүүтэй байдаг. Та нэмэлт хуримтлал хийх боломжтой. Хэрвээ танд гэнэтийн мөнгөний хэрэгцээ хадгаламжийн хугацаа дуусахаас өмнө гарвал та хугацаагүй хадгаламжаас ч бага хүү авна. Иймээс таны санхүүгийн төлөвлөлт чухал юм.

Хадгаламжийн сертификат

Энэ нь хугацаатай хадгаламжаас өндөр хүү төлдөг хатуу нөхцөлтэй бүтээгдэхүүний нэг юм. Өөрөөр хэлбэл, хадгаламжийн хугацааны дундуур орлого хийх ба хугацаанаас өмнө цуцлах боломжгүй байдаг. Харин мөнгөний хэрэгцээ гарсан бол бусдад шилжүүлэх, зарах, бэлэглэх замаар бэлэн мөнгө болгож болдог.

Дээрх нийтлэг хадгаламжийн төрлөөс гадна хүүний төлбөрийг хэдий хугацаанд ямар давтамжтайгаар өгч байгаагаас хамаарсан хадгаламжийн бүтээгдэхүүнүүд байдаг. Тухайлбал:

 Урьдчилсан хүүт хадгаламж- Хадгаламж нээлгэсэн даруй эсвэл сар бүр харилцах дансандаа авах хадгаламж юм. Хүссэн цагтаа орлого хийж болох ч данснаасаа хугацаанаас өмнө мөнгө авах бол хүүг бууруулсан хүүгээр тооцдог.

 Хүүнээс хүү тооцох хадгаламж- Сар бүрийн эцэст хуримтлагдсан хүүг тухайн хадгаламжийн дансанд шилжүүлэн хүүнээс хүү тооцдог ороо онцлог. Өөрөөр хэлбэл, жилийн хүү нь 13,3% байхад хүүнээс хүү бодсоноор таны хадгаламжид бодогдох бодит хүү 16,53% болж байна.

Эдгээр хадгаламжийн онцлогийг 6 сарын хугацаатайгаар 5000000 төгрөгийг хадгалах нөхцөл дээр харьцуулж үзье.



Хүснэгт 3.1. Хадгаламжийн хүүний орлого тооцоолол

Төрөл	Жилийн хүү	Жилийн бодит* хүү	Хүүнийхээ орлогыг тооцоолох (төгрөг)
Харилцах	0.00%	0%	0
Хугацаагүй хадгаламж	6.00%	6.00%	150,000.00
Энгийн хугацаатай хадгаламж	13.30%	13.30%	332,500.00
Хүүгээ сар бүр олгох урьдчилсан хүүт хадгаламж	15.40%	15.40%	385,000.00
Хүүнээс хүү тооцох хадгаламж	15.40%	16.53%	413,250.00
Хадгаламжийн сертификат	15.80%	15.80%	395,000.00

* Хадгаламжийн хугацаанд хэд хэдэн удаа хүү олгох тохиолдолд бодит хүүг тооцоолдог.



Арилжааны банк нь хадгаламж эзэмшигчдийн мөнгөн хөрөнгийг заавал даатгуулах хуулийн үүрэг хүлээдэг. Банк дампуурсан тохиолдолд хуулиараа таны хадгалуулсан 20.0 хүртэл сая төгрөг эсвэл түүнтэй тэнцэх хэмжээний валютын хадгаламжийг нөхөн олгохоор "Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай" хуульд заасан байдаг.



Нийт хадгаламж



Хуримтлагдсан хүү



Зээлтэй бол зээлийн хүү



Нөхөн төлбөрийн хэмжээ

Зураг 3.4. Нөхөн төлбөрийн бүтэц



3.3. Хэрхэн хадгаламжтай болох вэ?

Хадгаламж нь таны зорилго, мөрөөдөлтэй холбогдвол илүү үр дүнтэй болно. Өрхийн гишүүн бүр өөр өөрийн хүсэл зорилго, мөрөөдөлтэй байдаг.






Иймд мөрөөдөл, зорилгодоо хүрэхийн тулд хуримтлалынхаа төлөвлөгөөг гаргаж түүнд тууштай, санхүүгийн сахилгатай байх нь чухал.

Гишүүн бүрийн хүсэл зорилго, мөрөөдөл өрхийн санхүүтэй холбоотойгоор шийдэгдэх учир ач холбогдлын дарааллыг гарган өрхийн хуримтлалын төлөвлөгөө гаргаарай. Хүснэгт 1.2-т хуримтлалын төлөвлөгөөний жишээг авч үзлээ.



Хүснэгт 3.2. Гарьдын гэр бүлийн хуримтлалын төлөвлөгөө

2020 оны 1-р сар	Гарьдын гэр бүлийн өрхийн орлого сарын 2.0 сая төгрөг		
	 Аав Ээж	 Дунд хүү	 Отгон охин
Хуримтлалын зорилго	Хүүгийн хурим	Компьютер	Унадаг дугуй
Ач холбогдол	1	2	3
Хуримтлалын хэмжээ	5,000,000	1,000,000	200,000
Хуримтлалын хугацаа	10 сар	9 сар	6 сар
Хадгаламжийн төрөл	10 сарын хугацаатай хүүнээс хүү бодох хадгаламж	9 сарын хугацаатай хадгаламж	6 сарын хугацаатай хадгаламж
Хуримтлалын төлөвлөгөө	Өрхийн орлогынхоо 15%-ийг том хүүгийн хуримд, 5%-ийг 2 бага хүүгийн хэрэгцээнд зориулах.	Зуны амралтаараа ажиллаж төлбөрийн 50%-ийг өөрөө олох.	Тэмдэглэлт баяруудаар цугларсан мөнгөө мөнгөний гахайдаа хадгалах.

Гарьдын гэр бүл хуримтлалынхаа төлөвлөгөөний дагуу өрхийн орлогынхоо 27% буюу 540,000 төгрөгийг цалингийн данснаасаа хадгаламжийн данс руугаа шууд шилжүүлэх банкны үйлчилгээ авснаар хуримтлал хийхэд хялбар, үр дүнтэй болсон байна.

Бүх банкинд энэхүү үйлчилгээ байдаг бөгөөд нэршлийн хувьд харилцан адилгүй байдаг. Тухайлбал, зарим банк захиалгат шилжүүлгийн үйлчилгээ, стэндинг ордер буюу захиалгат гүйлгээ гэдэг бол зарим нь хуримтлалын үйлчилгээ ч гэж нэрлэдэг. Та ч мөн энэхүү үйлчилгээг авснаар санхүүгийн хувьд сахилгатайгаар хуримтлал хийх боломжтой.



ХЭРХЭН АВТОМАШИНТАЙ БОЛОХ ВЭ?

Одоо зээлэх үү?

Тэмүүлэн 2,192,369 төгрөгийн хадгаламжаар урьдчилгаа төлбөрөө төлөөд 10.0 сая төгрөгийн үнэтэй автомашин худалдан авахад зээлийн төлбөрт сард 716,447 төгрөг төлөхөөр байна.

Сул тал

1 жилийн хугацаанд зээлийн хүүнд 777,148 төгрөг төлөх ба зээл авахтай холбоотой нэмэлт зардлууд гарна

Давуу тал

Яг одоо автомашинтай болох боломжтой.

Нэг жилийн өмнөөс хуримтлуулах уу ?

Харин одоо зээл авахгүйгээр 2,192,369 төгрөгөө үргэлжлүүлэн 1 жил хадгалахдаа зээлийн төлбөрт төлөх байсан дүнтэй ойролцоо буюу 650,000 төгрөгийг сар бүр нэмж хийхэд 1 жилийн дотор зээлгүйгээр 10.0 сая төгрөгийн автомашинаа авах боломжтой.

Давуу тал

Харин эсрэгээрээ банк 882,414 төгрөгийн хүү таны хадгаламжид төлөхөөр байна.

Сул тал

Бүтэн жилийн дараа автомашинаа авна.

Тэмүүлэн, Солонго хоёрын охин Тамир энэ жил сургуульд орж байгаа ба охиноо сургуульд орох үед автомашин авахаар төлөвлөж, 1 жилийн өмнөөс хуримтлал хийж эхэлсэн. Энэхүү зорилгодоо зориулан гэр бүлийн сарын орлогынхоо 10%-ийг буюу **170,000** төгрөгийг сар бүр Солонгын цалингийн данснаас жилийн 15,6%-ийн хүүтэй хадгаламжид автоматаар хийх банкны үйлчилгээг сонгосон. Ингэснээр тэд төлөвлөсөн хугацаандаа **2,192,369** төгрөгийг хуримтлуулж чаджээ. Ийнхүү **10.0 сая** төгрөгийн автомашин лизингээр худалдан авах боломж бүрдэж байна.



3.4. Хадгаламжийн хүүний тооцоолол

Хүснэгт 3.4. Хадгаламжийн хүүг хэрхэн тооцдог вэ?







<p>Энгийн хадгаламж</p>	<p>Хадгалуулах мөнгөн дүн, хугацаа, хүүний хувийг ашиглан ирээдүйд өсөх мөнгөн хэмжээг тооцоолж болно.</p> $\text{Хадгаламжийн дүн} = \text{Анхны мөнгөн дүн} \times (1 + \text{хүү})^{\text{жил}}$ <p>Жишээ нь: 1 сая төгрөгийг, жилийн 12%-иар хадгалуулбал 3 жилийн дараа хэдэн төгрөгтэй болох вэ?</p> $\text{Хадгаламж} = 1,000,000 \times (1 + 0.12)^3 = 1,404,928 \text{ төгрөг}$
<p>Хүүнээс хүү бодох хадгаламж</p>	<p>Банкууд энэ төрлийн хадгаламжийг хүүгээр арвижих хугацаатай хадгаламж, хуримтлалын хадгаламж гэх мэтээр нэрлэдэг. Өмнөх жишээгээр сар бүр хүүнээс хүү тооцдог хадгаламжийн дүнг бодож үзье.</p> $\text{Хадгаламжийн дүн} = \text{Анхны мөнгөн дүн} \times \left(1 + \frac{\text{жилийн хүү}}{12}\right)^{(\text{жил} \times 12)}$ $\text{Хадгаламж} = 1,000,000 \times \left(1 + \frac{0.12}{12}\right)^{3 \times 12} = 1,430,768 \text{ төгрөг}$
<p>Сар бүр тогтмол дүнгээр хуримтлал үүсгэх хадгаламж</p>	<p>Тухайлбал, сар бүр 100000 төгрөгийн хуримтлалыг, жилийн 12%-ийн хүүтэй хадгална гэж үзвэл, 3 жилийн дараа хичнээн хэмжээний хуримтлалтай болсон байхыг бодъё.</p> $\text{Хадгаламжийн дүн} = \frac{\text{Сар бүрийн хуримтлалын дүн} \times (1 + \frac{\text{жилийн хүү}}{12})^{(\text{жил} \times 12)} - \text{жилийн хүү} / 12}{\frac{0.12}{12}}$ $\text{Хадгаламж} = 1000000 \times \frac{\left(1 + \frac{0.12}{12}\right)^{(3 \times 12)} - 1}{\frac{0.12}{12}} = 4,307,687 \text{ төгрөг}$



Жилийн хүүг бодохдоо хувийг тоон хэлбэрт шилжүүлдэг. Жилийн хүү **12%** бол энэ нь коэффициентээр бол **0.12** юм.

Харин сарын хүүг олохдоо жилийн хүүг 12-т хувааж гаргана. Тоон хэлбэрт оруулбал = **0,12/12** буюу **0.01** болох юм.

Та одоо хуримтлалгүй байсан ч одоогоос эхлээд хуримтлуулж болно. Хамгийн гол нь хуримтлал хийх зорилго болон төлөвлөгөөгөө гаргах хэрэгтэй.

-  Ямар хугацааны зорилго тавих вэ?
-  Зорилго маань урт, дунд, богино хугацааны аль нь вэ?
-  Ач холбогдлын дарааллаараа аль зорилго хамгийн чухал вэ?
-  Хуримтлал маань хэзээ хэрэгтэй болох вэ?
-  Хэдий хэмжээний мөнгө хэрэгтэй болох вэ?
-  Сард хэдийг хуримтлуулбал би зорилгодоо хүрэх вэ?

Тэмүүлэн, Солонго хоёр түрээсийн байранд 4 дэх жилдээ сууж байгаа. Тэдний хувьд түрээсийн төлбөрт зардал гаргаж байснаас орон сууцны зээлийн төлбөрт төлөх нь ирээдүйдээ хөрөнгө оруулж буй нэг хэлбэр гэж үзсэн. Залуу гэр бүл **50.0 сая** төгрөгөөр **1 өрөө орон сууц** худалдан авах хүсэлтэй, урьдчилгаа төлбөр **30%** болох **15.0 сая** төгрөгийг хуримтлуулж чадвал орон сууцны зээлд хамрагдах боломжтой болох юм. Тэмүүлэнгийн гэр бүлийн хувьд сард **350,000** төгрөгийн хуримтлал хийх боломжтой. Урт хугацаатай хадгаламжийн хүүг жилийн **15.6%** гэж үзвэл хэдэн жилийн дараа урьдчилгаа төлбөрөө бүрдүүлж чадах вэ?

Дээрх томъёог ашиглан Тэмүүлэнгийн гэр бүлийн хуримтлалын хэмжээг бодож үзье.

$$\text{Хадгаламж} = \text{Сар бүрийн хуримтлалын дүн} \times \frac{(1 + \text{жилийн хүү} / 12)^{(\text{жил} \times 12)} - 1}{\text{жилийн хүү} / 12}$$

$$(1 + 0.156 / 12)^{\text{жил} \times 12} = \left(\frac{15000000}{350000} \times 0.156 \right) / 12 + 1 \quad \text{Жил} = 2.7 \text{ жил}$$

Тэмүүлэнгийн гэр бүл **2.7 жилийн дараа** буюу **2 жил 9 сарын дараа** урьдчилгаа төлбөрөө бүрдүүлж чадахаар байна.



3.5. Хадгаламжид үзүүлэх инфляцын нөлөөлөл

Инфляц бидний худалдан авалтад нөлөөлөхөөс гадна хадгаламжийн орлогод нөлөөлдөг. Өөрөөр хэлбэл, инфляц хэдий чинээ их байна, хадгаламжийн хүүнээс олох орлогыг бууруулж байдаг. Дараах жишээгээр инфляц хадгаламжинд хэрхэн нөлөөлж байгааг хугацаагүй хадгаламжийн хүү 6% байх тохиолдолд бодит хүүг бодож үзье.

Хадгаламжийн бодит хүү = Хадгаламжийн нэрлэсэн хүү – Инфляцын хувь

Хүснэгт 3.5. Бодит хүүний тооцоолол (2018-2020 он)

Он	Бодит хүү	
2018	- 6.5% = 6% - 12.5%	Энэ үед хадгаламжийн хүү инфляцаас бага байх тул таны хадгалуулж буй мөнгө 6.5%-иар үнэ цэнэ нь буурч байна. Өөрөөр хэлбэл, энэ үед та бусад хэлбэрийн үнийн өсөлттэй байгаа зүйл хөрөнгө оруулах эсэхээ шийдэх хэрэгтэй. Тухайлбал, үл хөдлөх хөрөнгө худалдан авах гэх мэт
2019	- 5% = 6% - 11%	2018 онтой харьцуулахад арай дээр боловч мөнгөн хөрөнгө маань 5%-иар үнэ цэнээ алдахаар байна. Магадгүй бэлэн мөнгөө гэртээ хадгалсан бол таны мөнгөний үнэ цэнэ 11%-иар буурах байлаа.
2020	4.1% = 6% - 1.9%	Таны хадгалуулсан мөнгө 4.1% өсөлттэй байхаар байна.

Бодит хүү гэдгийг инфляцын нөлөөллийг тооцсон хүү гэж ойлгож болно.

